

АГУУЛГА

ХҮСНЭГТ	2
ОРШИЛ	3
I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	4
I.1. Төслийн зорилго.....	4
I.2. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	4
I.3. Ордын нөөц.....	4
I.4. Ордын ТЭЗҮ.....	4
I.5. Ордын уулын ажлын төлөвлөгөө.....	4
I.7. Ордын БОННУ.....	4
I.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулсан аргачлал.....	4
I.9. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн танилцуулга:.....	4
II. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
II.1 Ордын байршил.....	5
III.1. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс	6
III.1.1. Доголын өндөр.....	6
III.1.2. Ажлын бус доголын өндөр	6
III.1.3. Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг.....	6
III.1.4. Ажлын доголын хажуугийн өнцөг.....	6
III.2. Ил уурхайн хүрээ хязгаар	6
III.4. Ил уурхайн ажиллах горим	7
III.5.1. Ил уурхай уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө	8
III.5.5. Шимт хөрсний хуулах хөрсний зузаан.....	9
III.5.6. Хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө.....	10
III.5.7. Ил уурхайн технологийн процесс	12
III.5.8. Ил уурхайн тээвэр	13
III.5.8.1. Ил уурхайн авто зам.....	13
IV. ЭЛС УГААН БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ.....	13
IV.2. Гравитацийн баяжуулах процесс	14
IV.4.1.1. Ажилчдын унд-ахуйд усны хэрэглээ:.....	16
IV.4.1.2. Технологийн усны хэрэгцээ:	16
IV.4.1.3. Ил уурхайн усны хэрэглээ:.....	16
V. Барилга байгууламж	17
V. VI.10.1. Техникийн нөхөн сэргээлт.....	18
VII. ХОГ ХАЯГДАЛ	20
VIII. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	21
IX. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	21
IX.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	21
IX.2. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга	21
IX.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	22
IX.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	22
IX.5. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	22
IX.6. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	22
X.1.1. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	23
X.1.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
X.1.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө	25
X.1.4. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	26

Х.1.5. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	26
Х.2. Биологийн нөхөн сэргээлт-мод тарилт	28
Х.2.1. Мод тарихын экологийн ач холбогдол	29
Х.2.2. Мод, сөөг болон түүний бүтэц, зарим үүрэг	29
Х.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	30
Х.3. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	32
Х.4. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	32
Х.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө төлөвлөгөө ..	33
Х.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	33
Х.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	35
Х.7.1. Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах	35
Х.7.2. Хог хаягдлын тооцоо, судалгаа <i>Баяжуулах технологиос үүсэх хаягдал:</i>	36
Х.7.3. Аюултай хог хаягдал-техникийн тос	36
Х.7.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээ	38
Х.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	39
Х.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	40
Х.10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	41
Х.11. БОМТ-ний төсвийн нэгтгэл	41

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. тусгай зөвшөөрлийн талбайн солбицол.....	5
Хүснэгт 2. Ил уурхайн ашиглалтын технологийн схем.....	6
Хүснэгт 3. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн параметрууд.....	6
Хүснэгт 4. Уурхайн ажлын горим.....	8
Хүснэгт 5. Ил уурхай- 1 Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө	8
Хүснэгт 8. Шимт хөрс хуулах ажлын хэмжээ	9
Хүснэгт 9. Хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө	10
Хүснэгт 10. Хөрс тээвэрлэлт болон элс тээвэрлэлтийн зай	13
Хүснэгт 13. Барилга байгууламж	17
Хүснэгт 15. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..	23
Хүснэгт 16. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 17. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд.....	25
Хүснэгт 18. Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	26
Хүснэгт 19. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	26
Хүснэгт 20. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	30
Хүснэгт 21. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	32
Хүснэгт 22. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	32
Хүснэгт 23. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	33
Хүснэгт 24. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	33
Хүснэгт 25. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ.....	36
Хүснэгт 26. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	38
Хүснэгт 27. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	39
Хүснэгт 28. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	40
Хүснэгт 29. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	41
Хүснэгт 30. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл ..	41

ОРШИЛ

“Түм Их Эрхэд” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших 218.02 гектар талбай бүхий, MV-000784 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Нарийны алтны шороон орд шороон ордыг 2020 оны 07 дугаар сарын 20-ний өдөр шилжүүлэн авсан.

Нарийны алтны шороон орд ордын уул геологийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хучаас хөрсний зузаан зэрэгт үндэслэн ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд 2023 онд ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглахаар уулын ажлыг төлөвлөсөн.

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн эхний жилд хөрс хуулалтын ажлыг 7-р сараас 11-р сарын 15 хүртэл, элс угаалтын ажлыг 7-р сарын дунд үеэс 10-р сарыг дуустал үргэлжилнэ.

2025 онд нийт 1,480.05 мян.м³ уулын цул үүнээс 59.29 мян.м³ элс олборлож, 1,420.76 мян.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 24 м³/м³ байна.

Техникийн нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. техникийн ерөнхий шаардлага-MNS 5917:2008” стандарт болон БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу 2025 онд 11.63 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Биологийн нөхөн сэргээлтийг 1 га талбайд хийж гүйцэтгэнэ.

Манай компани нь БОАЖ сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу энэхүү 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Компани нь байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нэгэнт болсон сөрөг нөлөөллийг арилгах, болсны дараа арга хэмжээ авах гэсэн дараалал баримтлах бөгөөд төсөл хэрэгжих нутгийн иргэд болон сонирхогч талуудад төслийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зарчим баримтлан ажиллана.

I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

I.1. Төслийн зорилго.

Нарийны алтны шороон орд алтны шороон ордыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагааг явуулж, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар, байгалийн баялгийг зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, мөн компанийн ажилчид болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

I.2. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.

АМГТГ-ын Геологи, Уул уурхайн Кадастрын хэлтсийн даргын 2020.07.20-ны өдрийн 247 тоот шийдвэрээр “Нарины алтны шороон орд” нэртэй 252 га талбайд ашигт малтмал ашиглах MV-000784 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг Түмэн Их Эрхэд ХХК шилжүүлэн авсан.

I.3. Ордын нөөц.

Нарины алтны шороон орд алтны шороон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэж, 2021 оны 04 сарын 29 өдрийн ЭБМЗ-ийн хуралдааны ХХ-06-04 тоот дүгнэлтийг үндэслэн УГА-даргын 2022 оны 05 сарын 24-ны өдрийн Н/45 тоот тушаалаар нийт ордын нөөцийг бодитой (В) нөөц шлихээр 64.78 кг, химийн цэврээр (В) нөөц 60.09 кг, боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 11.04 кг, химийн цэврээр нөөц 10.24 кг, нийт (В+С) нөөц шлихээр 75.82 кг, химийн цэврээр 70.33 кг нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэл хүлээн авсан байна. Орд нь III бүлгийн шороон ордод хамаарна.

I.4. Ордын ТЭЗҮ.

Ордын ТЭЗҮ 2022 оны 09 сарын 15-ны өдрийн Т/22-09-04 тоот дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын 2022 оны 09 сарын 25 -ны өдрийн Т/51 тоот тушаалаар хүлээн авсан “Бал чулуу” ХХК боловсруулсан байна.

I.5. Ордын уулын ажлын төлөвлөгөө.

Ордын ТЭЗҮ дагуу 2025 оны 07 сарын 07 ний өдөр батлагдсан.

I.7. Ордын БОННҮ.

Ордын БОННҮ тайланг 2023 онд “Баялаг эко” ХХК боловсруулсан.

I.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулсан аргачлал.

БОАЖ сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу энэхүү 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

I.9. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн танилцуулга:

“Түм Их Эрхэд” ХХК нь 100% дотоодын хөрөнгө аж ахуй нэгж юм. Компани нь тусгай зөвшөөрлийг шилжүүлж авснаас хойш 2022 онд ордод гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр тайланг боловсруулан батлуулсан.

II. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

II.1 Ордын байршил.

Нарийны алтны шороон орд нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт, Улаанбаатар хотоос 450 км, Дархан хотоос 200 км, Шарын голын нүүрсний уурхайгаас 75 км зайд Толгойт, Сангийн гол, Шавартын голын уулзварт оршдог. (Талбайн байршлын зураг-1) Район нь Хэнтийн нурууны баруун хойд хажууд байрлах ба дунд зэрэг өргөгдсөн гадаргуутай. Районы хамгийн нам цэг нь далайн түвшнээс 1060 м өндөртэй Толгойтын голын хөндий, өндөр цэг нь 1,310 м өндөртэй өндөрлөг юм.

Талбайн хэмжээ: 218.02 гектар

Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: М - 48 - 95

ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь дараах солбицлоор хязгаарлагдана.

Хүснэгт 1. тусгай зөвшөөрлийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	107° 23' 16.36"	49° 28' 1.91"
2	107° 23' 16.36"	49° 28' 31.9"
3	107° 21' 34.99"	49° 28' 31.9"
4	107° 21' 35.08"	49° 28' 29.96"
5	107° 21' 34.92"	49° 28' 28.57"
6	107° 21' 34.07"	49° 28' 26.3"
7	107° 21' 32.31"	49° 28' 24.15"
8	107° 21' 30.24"	49° 28' 22.74"
9	107° 21' 21.96"	49° 28' 17.33"
10	107° 21' 14.13"	49° 28' 13.14"
11	107° 21' 2.82"	49° 28' 7.34"
12	107° 21' 1.36"	49° 28' 6.67"
13	107° 21' 1.36"	49° 28' 1.91"

Зураг 4. Тусгай зөвшөөрлийн байршил



III. ИЛ УУРХАЙ ТӨЛӨВЛӨЛТ

Орд нь мөнхийн цэвдэгшилгүй бөгөөд гэсгэлэн усны түвшин ашигт давхаргын доор байрлаж байгаа бөгөөд том ширхэгтэй хайрга чулуу байхгүй учир чулуулгийг ил аргаар олборлоход бэрхшээл бага байна.

Тууз хэлбэрийн багахан зузаантай хэвтээ байрлал бүхүй дөрөвдөгчийн алтны шороон ордын ашиглалтын систем ил уурхайн аргаар, авто тээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-батлагдсан.

Хүснэгт 2. Ил уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Ухаж ачих 1.2. Тээвэрлэх 1.3. Овоолох
	2. Элс олборлолт	2.1. Ухаж ачих 2.2. Тээвэрлэх 2.3. Овоолох

III.1. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс

Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн параметруудийг ордын чулуулгийн физик- механик шинж чанар болон ажиллах тоног төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлтүүдэд үндэслэн “Гипроруда”-ийн баримтлалын дагуу сонгосон.

III.1.1. Доголын өндөр

Элсний хаягдал, бохирдлыг бага байлгах, ухаж ачих тоног төхөөрөмжийн ажиллах нөхцөл зэргийг үндэслэн ил уурхайн ажлын доголын өндрийг $H_d=5$ м, элсний доголын өндөр $H_d=2.5$ м байхаар сонгосон.

III.1.2. Ажлын бус доголын өндөр

Уурхайн ажлын доголыг ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед доголуудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэх ба ажлын бус доголын өндөр /доголын хаалт/ нь 10 м байна.

III.1.3. Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг

Ил уурхайн хажуугийн өнцгийг ордын чулуулгийн физик-механик шинж чанарт үндэслэн тогтоосон. Уурхайн ашиглалтын технологийн элементүүд болох ажлын болон ажлын бус доголын өндөр ба доголын өнцөг, тээврийн ба аюулгүйн тавцангийн өргөн зэрэг ил уурхайн уулын ажлын параметруудээр байгуулж үзэхэд ерөнхий хажуугийн өнцөг 45-50 градус байна.

III.1.4. Ажлын доголын хажуугийн өнцөг

Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн физик механик шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож үндсэн чулуулагт 55 градус байхаар сонгосон.


Хүснэгт 3. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн параметрууд

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Ажлын доголын өндөр	м	5
2	Элсний доголын өндөр	м	2.5
3	Ажлын бус доголын өндөр	м	10
4	Ажлын доголын хажуугийн өнцөг	град	55
5	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	град	55
6	Ажлын талбайн өргөн	м	30
7	Траншейн дагуу налуу	промиль	80
8	Доголын аюулгүйн бермийн өргөн	м	3
9	Технологийн замын өргөн	м	12
10	Уурхайн хажуугийн ерөнхий өнцөг	град	45-50

III.2. Ил уурхайн хүрээ хязгаар

MV-000784 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 2025 оны уулын төлөвлөгөөгөөр нийт хөрсний хэмжээ 1.420 мян.м³, нийт элсний хэмжээ 59.29 мян.м³, алтны шороон ордын хэмжээнд нийт (B+C) зэрэглэлээр химийн цэврээр 56.19 кг-нөөц тус тус өртөж байна.

График 1. Үйлдвэрлэлийн элсний хэмжээ (блок тус бүрээр)




III.4. Ил уурхайн ажиллах горим

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн эхний жилд хөрс хуулалтын ажлыг 7-р сараас 11-р сарын 15 хүртэл, элс угаалтын ажлыг 7-р сарын дунд үеэс 10-р сарыг дуустал үргэлжлэхээр төлөвлөсөн.

Уулын ажил нь цаг агаарын саатал, төлөвлөгдөөгүй техникийн засвар үйлчилгээ, сул зогсолтоос хамааран эхний жилд баяр ёслол, амралтын өдрүүд 7 хоног, цаг агаараас хамаарсан сул зогсолт 14, уурхайн жилд ажиллах бодит хоног 120 хоног тус тус ажиллахаар байна.

Зураг 4. Ил уурхайн ажлын горим



Хүснэгт 4. Уурхайн ажлын горим

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Календарийн хоног	хоног	365
2	Баяр ёслол, амралтын өдрүүд	хоног	7
3	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	14
4	Төлөвлөгөөт сул зогсолт	хоног	194
5	Уурхайн жилд ажиллах бодит хоног	хоног	120
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
8	Ээлжийн сул зогсолт (цайны цаг)	цаг	1
9	Ээлжийн сул зогсолт (ээлж солилт, түлш тос, солилт)	цаг	1
10	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.83
11	Уурхайн хоногт ажиллах бодит цаг	цаг	20
12	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	3,000

III.5.1. Ил уурхай уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө


Ордын уулын ажлын календарьчилсан төлөвлөлтийг ордын уул геологийн нөхцөл, элс угаан баяжуулах хэсгийн хүчин чадал ажиллах техникуудийн хүчин чадалд тулгуурлан боловсруулав. Ил уурхай нь ашиглалтын жилийн хугацаанд нийт 1480.05 мян.м³ уулын цул үүнээс 59.29 мян.м³ элс олборлож, 1,420 мян.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 23.9 м³/м³ байна.

Хүснэгт 5. Ил уурхай- 1 Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Уулын ажил		Нийт
			III-р улиралд	IV-р улиралд	
1	Хөрс хуулалт	мян.м3	1,065	355	1,420
2	Элс олборлолт	мян.м3	44.50	14.80	59.30

3	Уулын цул	мян.м3	1,110	370	1,479.50
4	Алтны дундаж агуулга	мг/м3	1,153	841	1,055
5	Металл (х.ц)	кг	38.6	17.59	56.19
6	Хөрс хуулалтын дундаж коэффициент	м3/м3	23.93	24.00	23.95

График 2. Ил уурхай-1: Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө



III.5.5. Шимт хөрсний хуулах хөрсний зузаан

Хуулалтад хамрагдах үржил шимт болон потенциал үржил шимт хөрсний үе давхаргын зузааныг төслийн талбайд хийсэн хөрсөн бүрхэвчийн үржил шимт байдлын түвшний үнэлгээ, үндсэн хэв шинж ба дэд хэв шинжүүдийн хөрсний зүсэлтийн бие даасан генетик горизонтуудын хаяалбаруудын тус тусын үржил шимт байдлын үнэлгээ дээр үндэслэн үржил шимт хөрсийг 40 см-ээр MNS 5916:2008 стандарт шаардлагын дагуу Бульдозероор хуулж хадгална. Орд ашиглалтын 1 жилийн хугацаанд 3.2 га талбайгаас 13.05 мян.м³ шимт хөрс хуулах ба 0.45 га талбайд байршина.


Дээрх судалгаагаар хуулалтад хамрагдах үржил шимт хөрсний үе давхаргын зузааныг тогтоохдоо дараах үзүүлэлтүүдийг удирдлага болгосон байна. Үүнд: Хуулж буй үржил шимт үе давхаргуудын хольцын үржил шимт байдлын түвшин талбайн хөрсний хээрийн судалгаа, хөрсний зүсэлт, морфологийн бичиглэл, хайгуулын шугамын зүсэлтүүд зэргийг үндэслэжээ.

Хүснэгт 8. Шимт хөрс хуулах ажлын хэмжээ


Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилд			Нийт
			Өндөрийн жалга	Буянтны жалга	ДБС жалга	
1	Ил уурхай	м³	28,026.00	55,690.00	36,070.00	119,786.00
2	Гадаад хөрсний овоолго	м³	-	3,900.00	9,600.00	23,800
4	Шимт хөрсний овоолго	м³	4,680.00	5,400.00	5,200.00	17,800

5	Технологийн зам	м³	2,580	10,300	6,400.00	19,280
6	Нийт	м³	35,226.00	56,055.00	37,050.00	161,386.00

График 6. Шимт хөрс хуулах ажлын төлөвлөгөө



Зураг 8. Шимт хөрсийг бульдозероор хуулах технологийн бүдүүвч



III.5.6. Хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө

Шороон ордыг ашиглах үед хөрсний дотоод овоолгыг ашигласан блокийн ухаш, хоосон орон зайд экскаватороор шидэлт хийн үүсгэх ба гадаад овоолгыг автосамосвалаар тээвэрлэн бульдозерын тусламжтай овоолго үүсгэнэ. Орд ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 1,060.97 мян.м³ хөрс хуулах ба үүний 134,115 мян.м³ ийг гадаад овоолгод, 926,082 мян.м³ -ийг уурхайн дотоод овоолгод байршуулна. Хөрсний гадаад овоолго байрших талбайн хэмжээ 5.95 га байна.


Хүснэгт 9. Хөрсний овоолгын ажлын төлөвлөгөө

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилд			Нийт
			Өндөрийн жалга	Буянтн жалга	ДБС жалга	
1	Хөрс хуулалт	мян.м³	324,671	398,834	336,692	1,060,197
2	Сийрэгжилтийн коэффициент	-	1.15	1.15	1.15	1.15

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Нарийны алтны шороон орд ” нэртэй талбайд
2025 онд хэрэгжих байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	Гадаад хөрсний овоолго	мян.м3	71,549.00	123,968	42,930	134,115
4	Дотоод хөрсний овоолго	мян.м3	253,122	274,866	293,762	926,082

III.5.7. Ил уурхайн технологийн процесс



III.5.8. Ил уурхайн тээвэр

Тус ордыг оператор компанитай гэрээ байгуулан олборлох бөгөөд төсөл захиалагчаас ирсэн техникийн даалгаврын дагуу тулгуурлан HOWO фирмийн 25 тн даацтай 336 маркийн автосамосвалыг сонгож техникийн бүтээлийн тооцоог хийв.

Хүснэгт 10. Хөрс тээвэрлэлт болон элс тээвэрлэлтийн зай


Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жил		
			Өндөрийн жалга	Буянтын жалга	ДБС жалга
1	Хөрс тээвэрлэлтийн зай	км	0.8	0.7	0.4
2	Элс тээвэрлэлтийн зай	км	1.2	2.5	0.8

III.5.8.1. Ил уурхайн авто зам

Уурхайн бусад тээвэр. Уурхайн бусад ажил болон аж ахуйн хэрэгцээнд зориулж инженер техникийн болон бусад ажилчдыг зөөх суудлын машин, ажилчдын машин, уурхайн хэрэгцээний ачааны машин, тоног төхөөрөмжийн түлшний машин, зам талбайн усалгааны машин, зэрэг тээврийн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төсөлд тусгав.

Уурхайн туслах авто зам. Уурхайн олборлолтын ажлыг 1 жилийн хугацаанд гүйцэтгэх бөгөөд уурхайн хаалт нөхөн сэргээлтийг 2 дахь жилд хийж гүйцэтгэнэ. Уурхайг богино хугацаанд ашиглах тул гадаргуугийн технологийн авто зам нь байгалийн ердийн хөрсөн зам байна. Авто замын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу нэг урсгалтай, замын зорчих өргөн 12 м байна.

Зураг 10. Ил уурхайн автозамын паспорт



IV. ЭЛС УГААН БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ

IV.1. Угаан баяжуулах технологийн сонголт

Ордын элс угаан баяжуулах технологийн горимыг юуны өмнө шаварлаг эрдсийн хэмжээ, алтны оршин тогтсон хэлбэр, ялангуяа алтны ширхгийн хэмжээ, мөлгөржилт зэрэг олон үзүүлэлтээс хамааруулан гаргалаа.

Элсний угаагдах чадвар хялбар, жижиг ангиллын алт агуулсан байгаа нь гравитацийн баяжуулалтын энгийн, боловсронгуй технологи хэрэглэхэд тохиромжтойг туршилт, шинжилгээний үр дүнгүүд харуулж байна. Эндээс ордын элсний угаагдах чанар, алтны

хэмжээ болон техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг харьцуулан авч үзвэл ордын ашиглалтын үед элсний алтыг 90%-иас доошгүй гарган авах боломжтой.

IV.2. Гравитацийн баяжуулах процесс

Шлюзийн технологиор лабораторийн нөхцөлд энгийн шлюзээр баяжуулахад металл авалт 84.79% байна. Торын шинжилгээнээс үзэхэд 0.125 мм-ээс их фракцын алт 97.49% байгаа нь алтны баяжигдах чанар сайтай бөгөөд үйлдвэрлэлийн угаах төхөөрөмжөөр баяжуулах боломжтой гэж үзэж байна.

ПГШ-60 маркийн угаах төхөөрөмж нь ордын элсийг торхонд угаан зайлж 20 мм тороор шигшиж ангилна. Торны дээрх +20.0 мм ангиллыг дугуйт ачигчаар хайрганы тусгай овоолгод хурааж, -20.0 мм ангиллын элсээр шлюзийг тэжээнэ. Ангиллагдсан -20мм-ийн элс гүн дүүргэлтийн шлюзээр дамжин нам дүүргэлтийн хяналтын шлюзэнд баяжигдана.


Гравитацийн баяжмал буюу угаах төхөөрөмжүүдийн хяналтын шлюзэнд тогтсон баяжмалыг гүйцээн баяжуулах хэсэгт зөөвөрлөнө.

Угаах төхөөрөмжүүдийн шлюзийн хаягдлууд нь тунаах даланд өөрийн урсгалаар урсан орж хуримтлагдана. Хаягдлаас тунасан усыг цэвэршүүлэх далан руу шахааж, усыг эргэлтийн усны саванд хуримтлуулж насос, турба хоолойгоор дамжуулан баяжуулах үйлдвэрт технологийн эргэлтийн усаар ашиглана.


Гравитацийн баяжмал буюу угаах төхөөрөмжүүдийн хяналтын шлюзэнд тогтсон баяжмалыг гүйцээн баяжуулах хэсэгт зөөвөрлөнө.

Элс баяжуулахад гарах хаягдлыг хаягдлын санд хуримтлуулна. Хаягдлыг дахин үйлдвэрлэлд оруулж барилгын материал үйлдвэрлэх түүхий эд болгон хаягдалгүй технологи хэрэглэж болно.

Схем 1. Элс угаах технологийн схем



Схем 2. Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжийн холболтын схем



IV.4. Хотхоны усны хэрэглээ

Ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 56 хүн ажиллах боловч уурхайд байрлах ажилчны тоо хамгийн ихдээ 30 хүн, нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын хавсралтын дагуу тооцсон.

Усны хэрэглээ: Нарийны алтны шороон орд ордыг ашиглах үед цэвэр усны дараах үндсэн гурван хэрэглэгч байна. Үүнд:

-  Ахуйн усны хэрэглээ
-  Ил уурхай
-  Угаан баяжуулах цех

IV.4.1. Ашиглах усны хэмжээ:

Төслийн жилийн усны хэрэглээг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцов.

IV.4.1.1. Ажилчдын унд-ахуйд усны хэрэглээ:

Ашиглалтын 2025 жилийн хугацаанд нийт 56 хүн ажиллах боловч уурхайд байрлах ажилчны тоо хамгийн ихдээ 30 хүн, нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу 30 л/хоног-хүн байхаар тооцсон. Ахуйн усны хэрэглээ. Уурхай нь улирлын чанартай ажиллах учир 2025 онд 100 хоног ажиллахаар тооцсон бөгөөд унд ахуйн усны хэрэглээ өдөрт 0.9 м^3 , сард 27 м^3 , жилд – 90.0 м^3 (100 хоног) байна.

IV.4.1.2. Технологийн усны хэрэгцээ:

Ил уурхайн усны хэрэглээ: Ил уурхайн усны хэрэглэгч нь уурхайн зам, талбайн усалгаа зарцуулах ус байна. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын 13 дугаар хавсралтын дагуу 2 л/м^2 байна. Байгаль орчныг тоос шорооноос хамгаалах зорилгоор хур бороогүй хуурайшилттай өдөр уурхайн талбай, авто зам зэргийг усална. Уурхайн зам талбайн тоосжилт дархад шаардлагатай усны хэмжээ нийт $1,488 \text{ м}^3$ технологийн ус зарцуулна.

IV.4.1.3. Ил уурхайн усны хэрэглээ:

Технологийн усны хэрэгцээ: Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжид хэрэглэгдэх ил уурхайн ашиглалтаар үүссэн шүүрлийн нуураас болон гүний худгаас усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны сан байгуулна. Алт олборлож байгаа үйлдвэрүүдийн туршлага, түүнчлэн ордын элс угаах технологийн тооцоог баримталж шаардагдах усны 30%-ийг цэвэр усаар сэлбэх ба 70%-ийг технологийн эргэлтийн усаар хангах юм.

2025 оны жилийн хугацаанд тус алтны шороон ордын 59.29 мян. м^3 элсийг угаан баяжуулахад 237.160 мян.м^3 ус шаардагдах бөгөөд эргэлтийн усыг 70%-иар, үйлдвэрлэл эхлэхэд эхний 3 хоногийн хүдрийг баяжуулах технологийн 25.5 мян. м^3 усыг нөөцөлнө гэж тооцвол үйлдвэрлэлийн 2025 оны хугацаанд 96.648 мян. м^3 цэвэр ус технологид шаардлагатай.

V. Барилга байгууламж


Төслийн хугацаанд ажилчдын хотхонд хамгийн ихдээ 30 хүн байрлах бөгөөд амрах байр, удирдлагын байр, засварын газар, гал тогоо, агуулах, угаалга, бие засах, шүршүүрийн байрууд байхаар төлөвлөсөн. Ажилчдын байр хүн амьдрахаар тохижуулсан гэр байх бол шүршүүр, угаалга, бие засах газар мөн засаж тохижуулсан 40 тн-ын 2 ширхэг контейнер байна. Удирдлагын байр болон гал тогооны байр нь сэндвичээр барьсан 1 давхар байр байна.

Засварын газар болон харуулын байруудыг сэндвичэн хавтангаар байгуулах ба сэлбэг, тос тосолгооны материалын агуулах нь контейнерууд байна. Мөн шатахуун түгээх станцыг байгуулна.

Хүснэгт 13. Барилга байгууламж

Д/д	Барилга, байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
Уурхайн хотхон				
1	Уурхайн удирдлагын байр	м2	36	2 өрөөтэй 1 давхар байр
2	Ажилчдын сууц	ш	19	Тохижуулсан гэр
3	Цайны газар, гал тогоо	м2	54	Тохижуулж гэр
4	Бие засах, халуун ус болон угаалга	м2	60	40 тонны 2 контейнерыг холбон тохижуулна.
5	Цэвэр ус хадгалах сав	ш	1	20 м ³ -ийн багтаамжтай сав байна.
6	Ахуйн бохир хадгалах сав	м2	10	Газар доор 20 м ³ -ийн багтаамжтай сав байгуулна.
7	Сагсан бөмбөгийн талбай	м2	450	Ажилчид чөлөөт цагаа өнгөрөөх
Ил уурхай				
1	Засварын газар	м2	100	Сэндвичээр 12х8 м хэмжээтэй байр барина.
2	Шатахуун түгээх газар	м2	15	50 тонны багтаамжтай сав
3	Сэлбэгийн агуулах	м2	15	20 тонны контейнер
4	Тос тослох материал агуулах	м2	30	40 тонны контейнер
5	Харуулын байр	м2	27	9 м2 талбайтай 3ш сэндвичин байр
6	Уурхайг тойрсон хашаа	м	4,521	1.5 м-ийн өндөртэй торон хашаа

Зураг 11. Уурхайн хотхоны загвар



V. VI.10.1. Техникийн нөхөн сэргээлт

Нөхөн сэргээлт хийх объектуудад уурхайн ажиллагсдын тосгон, баяжуулах, боловсруулах үйлдвэр, хаягдлын сан байгуулах болон уурхайн ухааш, уулын ажлын нөлөөгөөр өртөж эвдэрсэн дараах газрууд хамаарна:



- Хөрс хуулалтын гадаад овоолго;
- Хурдас чулуулгийн овоолго;
- Ил уурхайн ухааш;
- Зайлдас (шлам) ба хаягдлын агуулах, тунгаагуур, цөөрмүүд;
- Асгадас, далан, суваг шуудуу;
- Баяжуулах үйлдвэрийн орчны талбай;
- Уурхайн дотоод, гадаад тээврийн замууд;
- Уурхайн хотхон;


Техникийн нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага-MNS 5917:2008” стандарт болон БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу 11.63 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Техникийн нөхөн сэргээлтийг ашиглалтын эхний жилд хийж гүйцэтгэнэ. Техникийн нөхөн сэргээлтийн ажлаар дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:

1. Хөрсний гадаад овоолгыг хэвгийжүүлэн нөхөн сэргээх;
2. Дотоод овоолгоор уурхайн ашиглагдсан талбайг нөхөн дүүргэх;

VI.10.1.1. Уурхайн ашиглалтын явцад үүссэн гадаад овоолгын нөхөн сэргээлт

Овоолгын нөхөн сэргээлтийн үндсэн ажил нь овоолгын гадаргууг засаж тэгшлэх, налууг багасгах болон дэвсэг үүсгэх ажиллагаа байдаг. Орд ашиглалтын 2025 оны хугацаанд нийт 492.064 мян.м³ хөрсийг гадаад овоолгод байршуулах ба овоолгын сийрэгжсэн хэмжээ 541.270 мян.м³ болно. 2025 оны 5.47 га талбайд гадаад овоолгын нөхөн сэргээлт хийнэ. Нөхөн сэргээлтэд зориулж, налууг багасгахдаа цаашид нурулт, гулсалт үүсэх, усанд угаагдаж эвдрэх, салхинд элэгдэхээс урьдчилан сэргийлэх арга ажиллагааг авч хэрэгжүүлэх нь чухал. Овоолгын налууг багасгахад түүний үндсэн хэмжээснүүд (налуугийн өнцөг, дэвсгийн өргөн, дэвсгүүдийн хоорондын зай г.м), хурдсыг дээрээс доош, шилжүүлэн түрэх аргыг ашиглана.

Зураг 18. Овоолгын налууг дээрээс доош түрж багасгах бүдүүвч



Гадаад овоолгод тэгшилсэн талбайн нийт хэмжээгээр шимт хөрснийг тараан байрлуулж, 20 см зузаантай хучилт хийнэ.


VI.10.1.2. Уурхайн дотоод овоолгын нөхөн сэргээлт

Орд ашиглалтын 2025 жилийн хугацаанд нийт 738.970 мян.м³ хөрс дотоод овоолгод байрших бөгөөд овоолгын сийрэгжсэн хэмжээ 812.867 мян.м³ болно. Уурхайн ашиглалтын технологиос хамаарч дотоод овоолгыг бульдозероор орчин тойрны газрын тогтоцтой ойролцоо хэлбэртэйгээр хэлбэршүүлнэ. Дотоод овоолгыг нөхөн сэргээхдээ дараах байдлаар хэлбэршүүлнэ. Үүнд:

-  Орчны газрын тогтоц (ландшафт)-ыг харгалзан тохиромжтой хэлбэр төрх үүсгэж налуулах;
-  Дотоод овоолгыг түрэх бульдозерын ажиллагааны нөхцөлд тулгуурлан овоолгын оройг хэлбэршүүлэх;
-  Хэлбэршүүлсэн талбайн гадаргуу, ялангуяа налуу хажууг бульдозерын сийрэгжүүлэгчээр 30-50 см гүнтэйгээр хөндлөн сэндийлж, уг гадаргууг хучсан шимт хөрс аадар борооны уруйн усанд идэгдэхээс хамгаалах;
-  Талбайн гадаргыг машин механизм явахад саадгүй байхаар хэлбэршүүлэх;
-  Хэлбэршүүлсэн газрын хажуугийн орой, хормойг алсаас 10-30-аар налуулж, тэгшилнэ;

Хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучиж, тэгшлэн булдаж, чийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр техникийн нөхөн сэргээлтийн ажил дууссан гэж үзэж, биологийн нөхөн сэргээлтэд шилжүүлнэ.

Зураг № 19. Дотоод овоолгоор уурхайн ашиглагдсан талбайг нөхөн дүүргэх технологийн бүдүүвч



VI.10.2. Биологийн нөхөн сэргээлт

Ил уурхайн ашиглалтын эхний жилд нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны техникийн үе шат бүрэн дуусаж, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсөөр хучилт хийсний дараа ашиглалтын жилд 1 га эвдэрсэн талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.

VII. ХОГ ХАЯГДАЛ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй.

“Түм Их Эрхэд” ХХК-ний “Нарийны алтны шороон орд” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц хатуу, шингэн хог хаягдал гарахгүй. Төсөл хэрэгжих явцад гарах хог хаягдлыг гарал үүслээр нь:

А. Ахуйн хог хаягдал

Б. Технологийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал нь ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас үүснэ. Хэлбэрээр нь:

1. Хатуу

2. Шингэн

3. Хийн гэж ангилна.

Төсөл хэрэгжих хугацаанд дараах зарчмыг дагаж мөрдөж ажиллана.

Зураг № 20. Уурхайн хог хаягдлын менежмент



Эдэлгээг сайжруулах буюу Сэргийлэх – гүйцэтгэгч байгууллагууд аливаа нөөцийг ариг гамтай зохицуулах, ашиглах замаар хог хаягдал бага гаргах. Үүний тулд худалдан авалт, хангамжийн сайн туршлага болох сав, баглаа боодол багасгах, цэгцтэй байлгах зэргийг хангах /Төслийн хэрэгжих явцад ашиглах бүх нөөцийг ариг гамтай ашиглаж, эдэлгээг уртасгана./

Эрс багасгах-Төсөл хэрэгжүүлэгч аливаа нөөцийг ариг гамтай зохицуулах, ашиглах замаар хог хаягдал эрс багасгах арга хэмжээг урьдчилан авах

Эргүүлж ашиглах – цэвэр шороог нүх булах зэргээр хог хаягдлыг талбай дээр байгальд халгүй байдлаар дахин ашиглах. Дахин ашиглах зарим хаягдлыг зохих газруудад худалдаж эсвэл үнэгүй нийлүүлэх. /Төслийн хэрэгжих явцад гарсан шороо байгальд халгүй эргүүлж ашиглах /

Эргүүлж боловсруулах – эргүүлж боловсруулах хаягдлыг цуглуулж, зохих газруудад худалдаж эсвэл үнэгүй нийлүүлэх. /Төслөөс гарах эргүүлж боловсруулах боломжтой бүх хаягдлууд хамаарна. Жишээ нь: ажилласан тос тосолгооны материал, хуванцар сав, гялгар уут, элдэв төмрийн хог хаягдал, хайрцаг сав баглаа боодол/

Эцэслэн хаях - эргүүлж ашиглах болон боловсруулах боломжгүй хаягдлыг хотын төвлөрсөн хогийн цэг рүү ТҮГ-аар тээвэрлүүлэн зайлуулах /Төслөөс эцэст нь гарах бүх хог хаягдлууд хамаарна./

VIII. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: Нарийны алтны шороон орд уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2023 онд “Баялаг эко” ХХК-ийн боловсруулсан алтны шороон орд ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: Нарийны алтны шороон орд уурхайн MV-000784 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл.

IX. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нарийны алтны шороон орд алтны шороон орд олборлох төслийн БОНБНҮ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

IX.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

БОННҮ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хөрсний овоолгууд ил уурхай зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй.

Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

-  Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох
-  Баяжуулах орчмын талбайгаас тоосжилт бий болох
-  Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникууд агаар орчныг бохирдуулах
-  Хөрс болон элс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх

IX.2. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга

“Түм Их Эрхэд” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэмнэлттэй хэрэглэх, усны хэрэглээг хамгийн бага

түвшинд хүргэх, усны дахин ашиглалтыг 80 хувиас дээш байлгах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэдийн хэрэглээний усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажиллана.

БОННУ-ийн дагуу усны нөөц, чанарт учирч болзошгүй дараах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоод байна. Үүнд:

-  Усны менежментийн төлөвлөлтийг зөв оновчтой гаргаагүйгээс уурхай үйл ажиллагаанд хэмнэлт, дахин ашиглахгүй ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах
-  Эргэлтийн усан санд усан толионоос ууршилт бий болж, усны алдагдал үүсэх
-  Газрын доорх усыг ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учирч болзошгүй
-  Тунаах далан, эргэлтийн усан сангийн уснаас нэвчилт үүсэх болон далан сэтрэх зэрэг ослоос процессын ус алдагдаж, хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй

IX.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

